



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1015 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

「 Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын
албаны эргэлтийн бус хөрөнгийг данснаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын албаны эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5 нэр төрлийн нийт 1,408,343.40 (нэг сая дөрвөн зуун мянга гурван зуун дөчин гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын алба (Д.Төмөрбаатар)-нд зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 1,408,343.40 (нэг сая дөрвөн зуун найман мянга гурван зуун дөчин гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгахыг Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын алба (Д.Төмөрбаатар)-нд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.



ДАРГА **В.ОЮУМАА**

